



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Г Хорооны 2011 оны 45 дугаар тогтоолын Г
хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банкны тухай хуулийн 6.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д дор дурдсан агуулгатай 2.5, 2.6, 3.2.4, 4.3 дах заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ “2.5 “Андеррайтерийн үйлчилгээ эрхлэхийг хүссэн банкны хувьд эрсдлийн сангийн хэмжээг анх 30 сая төгрөгөөр тогтоох ба цаашид андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тухай бүрд нь эрсдлийн сангийн хэмжээг Хороо тогтооно”,

2/ “2.6 “Банкны андеррайтерийн үйл ажиллагааны эрсдлийн сангийн мөнгөн хөрөнгийг өөр банкинд нээсэн тусгай дансанд байршуулна”,

3/ “3.2.4 “Банк андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүний бүтэц, хувьцаа эзэмшигчдийн талаарх Монголбанкны тодорхойлолт”,

4/ “4.3 “Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх банкны хувьд Хорооны “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 4.12, 4.13 дахь заалтууд хамаарахгүй”.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үнэт цаасны газар / Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дүгэржав/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН